MONGOLIAN
STOCK EXCHANGE

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН
# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
# ТУШААЛ

2014 оны 06 сарын 24 өдөр Дугаар 94 Улаанбаатар хот

*Үнэт цаасны бүртгэлд*
*өөрчлөлт оруулах тухай*

Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 12-р сарын 04-ний өдрийн 55 тоот тогтоол, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 57-р заалт, "Сүү" хувьцаат компанийн 2014 оны 05-р сарын 27-ны өдрийн 1/404 тоот хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн шалгалтын тайланг тус тус үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанид бүртгэлтэй "Сүү" хувьцаат компанийн төрийн мэдлийн 175,440 ширхэг хувьцааг хувьд шилжүүлэн бүртгэлд өөрчлөлт оруулсугай.

2. Холбогдох мэдээллийн санд өөрчлөлт оруулж, "Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанид хадгаламжид өөрчлөлт оруулах мэдэгдэл хүргүүлэхийг Үйл ажиллагааны газар /Б.Тунгалаг/-т үүрэг болгосугай.

3. "Сүү" хувьцаат компайин үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсон тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Зах зээлийн хөгжлийн газар /Ж.Мягмарсүрэн/-т даалгасугай.

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ** **Д. АНГАР**

ХӨРӨНГИЙН МОНГОЛЫН БИРЖ ХК MONGOLIAN STOCK EXCHANGE ТТА2380 ... 2071 ... 96 УЛААНБААТАР ХОТ

2014 оны 06-р сарын 24

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО**
**ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-Д**

ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИНД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ МЭДЭГДЭЛ № 135-д

Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 12-р сарын 04-ний өдрийн 55 тоот тогоол, МХБ-ийн гүйцэтгэх захирлын 2014 оны 06-р сарын 24-ны өдрийн № 94 тоот тушаалын дагуу хадгаламжид дараах өөрчлөлт оруулахыг мэдэгдье.

| **ҮЗҮҮЛЭЛТ** | | **ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ** | |
|---|---|---|---|
| | | **Бүртгэгдсэн байдал** | **Бүртгэлд орох өөрчлөлт** |
| **Үнэт цаасны нэр:** | | "Сүү" ХК | "Сүү" ХК |
| **Үнэт цаасны үсгэн код:** | | SUU | SUU |
| **Үнэт цаасны төрөл:** | | Хувьцаа | Хувьцаа |
| **Үнэт цаасны хэлбэр:** | | Энгийн | Энгийн |
| **Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/** | | 344,000 | 344,000 |
| Үүнээс : Төрийн эзэмшил | тоо /ширхэг/ | 175,440 | 0 |
| | хувь /%/ | 51 % | 0 % |
| Олон нийтийн Эзэмшил | тоо /ширхэг/ | 168,560 | 344,000 |
| | хувь /%/ | 49 % | 100 % |
| **Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/** | | 100 | 100 |
| **Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/** | | 34 400 000 | 34 400 000 |

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ — Д. АНГАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА — Б. ТУНГАЛАГ

VI/24